



Australian Government
Department of Immigration
and Border Protection

Оюутны хялбаршуулсан визний журам

Үндсэн өөрчлөлтүүд

Оюутны хялбаршуулсан визний журмыг (ХОВЖ) 2016 оны 7-р сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөж эхлэнэ.

ОХВЖ нь оюутнуудад чиглэл өгч оюутны визийг үнэн бодитоор мэдүүлэх ажиллагааг энгийн, хялбар болгон улмаар, цагаачлалын үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангахад чиглэсэн арга замыг нэвтрүүлж, байгууллагын шийдвэр гаргах шат дарааллыг багасгах зорилготой юм. Энэхүү мэдээллийн хуудсанд ОХВЖ-г 2016 оны 7-р сарын 1-нээс өмнөх оюутны виз хянан шийдвэрлэж байсан журамтай харьцуулах байдлаар үндсэн өөрчлөлтийг тоймлон харуулав.

Оюутны виз мэдүүлэх

2016 оны 7-р сарын 1-нийн өдрөөс хойш мөрдөх өөрчлөлт:

- гадаад оюутнууд сонгосон сургалтын чиглэлээс үл хамааран нэг ангиллын оюутны виз (ангилал 500) мэдүүлэх;
- оюутны асран халамжлагч оюутны асран халамжлагчийн (ангилал 590) шинэ ангиллын виз мэдүүлэх
- Бүх оюутнууд болон оюутны асран халамжлагч ImmiAccount дээр бүртгүүлж визний мэдүүлгийг цахим хэлбэрээр гаргана ImmiAccount-ын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг www.border.gov.au/Trav/Visa/Immi хаягааравна уу.

Цагаачлалын эрсдэлийг үнэлэх нэгдсэн журам -англи хэлний мэдлэг болон санхүүгийн чадавхид тавигдах шаардлага

2016 оны 7-р сарын 1-ний өдрөөс эхлэн бүх гадаад оюутанд цагаачлалын эрсдэлийг үнэлэх нэгдсэн журмыг мөрдүүлэх бөгөөд , өмнө нь мөрдөж байсан хялбарчилсан виз мэдүүлгийн болон визний үнэлгээний зэрэглэлийг цаашид ашиглахгүй.

ОХВЖ-ын дагуу тухайн оюутны визний мэдүүлэгтэй хамт гаргах шаардлагатай англи хэлний болон санхүүгийн чадварыг нотлох баримтын үнэн бодит байдлыг оюутны иргэний харьяалал болон суралцах гэж буй боловсролын байгууллагатай холбоотой цагаачлалын эрсдэлийн нэгдсэн үнэлгээг харгалзан үзэж тогтооно. ашиглана.

Хялбарчилсан нотлогоонд тавигдах шаардлага

ОХВЖ-аар цагаачлалын эрсдэл хамгийн бага оюутнууд хялбарчилсан нотлогоо гаргах шаардлагатай. .

Оюутнууд Цагаачлалын албанд санхүүгийн чадавхийг англи хэлний мэдлэгийн түвшинг Элсэлтийн батламжийн хуулбарийг хавсаргаж нотлоно.

Цагаачлалын алба шаардлагатай үед нэмэлт нотлогоо баримт гаргахыг шаардах х эрхтэй.

Үйлчилгээний цахим хэрэгсэл

Оюутнууд 2016 оны 5-р сарын сүүлээс эхлэн Цагаачлалын албаны цахим хуудас дахь цахим хэрэгслийн загвар руу хандаж оюутны визний мэдүүлэгт хавсаргах шаардлагатай материал, нотлох баримтын бичгийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл авах боломжтой. Цахим хэрэгсэл 2016 оны 7-р сарын 1-ний өдрөөс эхлэн албан ёсоор ажиллах бөгөөд виз мэдүүлэгч нь виз мэдүүлгийн аль ч үе шатанд, тухайлбал визний мэдүүлгийг цахим хэлбэрээр илгээхээс өмнө ч энэхүү хэрэгслийг ашиглаж болно.

Санхүүгийн чадавхи

ОХВЖ-ын дагуу- оюутны виз мэдүүлж буй бүх хүмүүс Австрали Улсад байх хугацаанд хангалттай хөрөнгийн эх үүсвэртэй гэдгийг нотлох ёстой.

Тухайн оюутны иргэний харьяалал, суралцах гэж буй боловсролын байгууллагын талаарх цагаачлалын эрсдэлийн үнэлгээнд тулгуурлан цагаачлалын эрсдэл өндөр гэж үнэлэгдсэн оюутнууд визний мэдүүлэгтээ санхүүгийн чадавхийг нотлох нэмэлт баримт материал бүрдүүлж өгөх шаардлагатай болно.

Цагаачлалын албаны үйлчилгээний цахим хэрэгсэлд санхүүгийн чадавхийг нотлох баримт шаардлагатай гэж заасан тохиолдолд виз мэдүүлэгч визний мэдүүлгийг хүргүүлэхээс өмнө эдгээр баримт бичгийг хавсаргасан байна. Эдгээр баримт бичгийг хавсаргаагүй тохиолдолд виз олгохоос татгалзах үндэслэл болно.

Санхүүгийн чадавхийг нотлох нэмэлт материал шаардлагатай тохиолдолд оюутан дараахь материалын аль нэгийг гаргаж өгөн нотлох боломжтой Үүнд:

- өөрийн болон гэр бүлийн гишүүдийнхээ Австрали Улсад зорчих зардал, Австрали Улсад 12 сарын хугацаанд амьдрах амьжиргааны зардал, сургалтын төлбөр болон сургуулийн насны хүүхдийн сургалтын төлбөрийг төлөх санхүүгийн эх үүсвэртэй гэдгээ нотлох баримт; **эсвэл**
- жилийн орлогын шалгуурыг хангаж байгаагаа нотлох баримт; **эсвэл**
- Дунд сургуулийн солилцооны сурагчдын мэдэгдлийн (ДСССМ) (зөвхөн дунд сургуулийн солилцооны сурагчдын хувьд) маягт гэх мэт.

Жилийн орлогын шалгуурыг хангахын тулд оюутнууд жилд 60000 австрали доллароос багагүй орлоготой болохыг баримтаар нотлох шаардлагатай юм. Гэр бүлийн гишүүдтэй хамт явах оюутнуудын хувьд жилд 70000 австрали доллароос багагүй орлого

олдог байх шаардлагатай. Нотолж буй орлого нь зөвхөн тухайн оюутны өөрийн болон түүнийн эхнэр/нөхөр эсвэл эцэг эхийн орлого байх ёстой. Оюутны эцэг эх хоёулаа ажил эрхлэх тохиолдолд тэдний орлогын нэгдсэн дүнг энэ шалгуурт авч үзэж болно. Жилийн орлогыг татварын тайланг гэх мэт төрийн байгууллагын албан ёсны мэдэгдэл, баримтаар нотолно.

12 сарын амьжиргааны зардалд тавигдах шаардлага нь үндсэндээ 2016 оны 7-р сарын 1-ний өдрөөс өмнө нь ашиглаж байсан үнэлгээний 2-р зэрэглэлийн оюутнуудад тавьдаг байсан шаардлагатай төстэй юм. Шаардлагатай үед гаргах нотлох баримтын төрөлд санхүүгийн байгууллагад байршуулсан мөнгөн хөрөнгө эсвэл зээл, засгийн газрын зээл, тэтгэлэг эсвэл ивээн тэтгэснийг нотлох баримт бичиг зэргийг хамруулна.

Амьжиргааны зардал

2016 оны 7-р сарын 1-ний өдрөөс эхлэн 12 сарын амьжиргааны зардлыг дараахь байдлаар тооцно:

- Оюутан/асран халамжлагч 19830 австрали доллар
- Хамтран амьдрагч/эхнэр/нөхөр 6940 австрали доллар
- Хүүхэд 2970 австрали доллар

Австралийн хэрэглээний үнийн индекс (ХҮИ)

Тухайн жилийн орлого, амьжиргааны зардал болон сургуулийн төлбөр зэрэг шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийн хэмжээг өмнөх календарын жилийн ХҮИ-г дагуу тогтмол хянаж, өөрчлөнө.

Олон улсын англи хэлний мэдлэгт тавигдах шаардлага

Оюутны англи хэлний мэдлэгийн түвшинг тогтооход шалгалтад дараах хүлээн зөвшөөрөгдөх оноог авсан байхыг шаардана. Үүнд:

- Олон улсын англи хэлний мэдлэгийн шалгалтын систем (International English Language Testing System, IELTS) нийт 5,5 оноо авсан байх; **эсвэл**
- Гадаад оюутнуудад зориулсан англи хэлний эрчимжүүлсэн сургалтад (English Language Intensive Course for Overseas Students, ELICOS) 10 долоо хоногоос багагүй хугацаанд сурахаар бүртгүүлсэн бол IELTS-ийн нийт 5 оноо авсан байх; **эсвэл**
- Гадаад оюутнуудад зориулсан англи хэлний эрчимжүүлсэн сургалтад (ELICOS)-т 20 долоо хоногоос багагүй хугацаанд сурахаар бүртгүүлсэн бол IELTS-ийн нийт 4,5 оноо байх шаардлагатай.

Англи хэлний дараахь шалгалтуудад IELTS-ийн хүлээн зөвшөөрөгдөх оноотой дүйцэхүйц оноо авсан байж болно. Үүнд :

- Төрөлх хэл нь англи биш хүмүүсийн англи хэлний түвшин тогтоох шалгалтын (Test of English as a Foreign Language paper based test, TOEFL) цаасаар өгдөг хувилбар;
- Их дээд сургуульд суралцах англи хэлний түвшин тогтоох Пеарсоны шалгалт (Pearson Test of English Academic)
- Кэмбрижийн англи хэлний шалгалт (Cambridge English): Ахисан түвшний (Advanced) болон
- Мэргэжлийн англи хэлний шалгалт (Occupational English Test).

Цагаачлалын албаны үйлчилгээний цахим хэрэгсэл нь англи хэлний мэдлэгийн түвшинг нотлох баримт шаардлагатай гэж заасан тохиолдолд виз мэдүүлэгч визний мэдүүлэг гаргахаас өмнө эдгээр баримт бичгийг хавсаргана. Эдгээр баримт бичгийг хавсаргаагүй тохиолдолд виз олгохоос татгалзах үндэслэл болно.

Англи хэлний мэдлэгийн түвшинд тавигдах шаардлагаас чөлөөлөгдөх тохиолдол

р Цагаачлалын эрсдэлийн зэрэглэлээс үл хамааран зарим оюутнууд англи хэлний мэдлэгийн түвшин тогтоох шалгалтын онооны нотлох баримт гаргах шаардлагаас чөлөөлөгддөг.

Англи хэлний мэдлэгийн түвшинд тавигдах шаардлагаас чөлөөлөгдөх ангиллыг хуулиар тогтооно..

Англи хэлний мэдлэгийн түвшинд тавигдах шалгуурын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг *Англи хэлэнд тавих шаардлагууд* х мэдээллийн хуудаснаас үзнэ үү .

Гадаад оюутнуудад зориулсан англи хэлний эрчимжүүлсэн сургалт (English Language Intensive Course for Overseas Students, ELICOS)

ОХВЖ-ын дагуу Англий хэлний эрчимжүүлсэн сургалтанд (ELICOS) хамрагдах хугацаанд хязгаарлалт тавьдаггүй. Оюутнууд Англий хэлний эрчимжүүлсэн сургалтанд (ELICOS) дагнан суралцах буюу шаардлагатай бол үндсэн сургалтын өмнөх англи хэлний бэлтгэл сургалтанд хамрагдаж болно.

Сургуульд элссэнг нотлох баримт

Австрали Улсын нутаг дэвсгэрээс гадна оршин сууж буй гадаад оюутнууд итгэмжлэгдсэн сургалтанд бүртгүүлэх байх ёстой бөгөөд оюутны визний мэдүүлэг гаргахдаа Сургуульд элсэн орсон батламжийг (Confirmation of Enrolment, CoE) хавсаргана. .

Австрали Улсын нутаг дэвсгэр дээр оршин сууж буй оюутнууд виз мэдүүлэхдээ сургуулийн урилга эсвэл Сургуульд элсэн орсон батламжийг хавсаргаж болох бөгөөд виз олгохоос өмнө Сургуульд элсэн орсон батламжийг авсан байх шаардлагатай.

Гадаад харилцааны яам, Батлан хамгаалах яамны тэтгэлэгт хөтөлбөрөөр суралцах оюутнууд (Гадаад харилцааны яам болон Батлан хамгаалах яамнаас гаргасан бичиг); дунд сургуулийн солилцооны сурагчид (дунд сургуулийн солилцооны сурагчдын зөвшөөрлийн мэдэгдлийн маягтуудыг хавсаргана. Судалгааны ажлын зорилгоор Австралид үлдэн магистр, докторын зэрэг хамгаалах оюутнуудад энэхүү шаардлага хамаарахгүй.

Сургалтын хөтөлбөрийг өөрчлөх

2016 оны 7-р сарын 1-ний өдрөөс эхлэн 500 ангиллын оюутны визтэй () докторын зэрэг горилох сургалтанд (AQF10) хамрагдаж байгаа болон магистрын сургалт руу (AQF9) шилжихээс бусад тохиолдолд анх виз олгосон Австралийн Мэргэжлийн Зэрэг олгох (AQF) түвшинтэй ижил эсвэл түүнээс дээш түвшинд үргэлжлүүлэн суралцахад шаардагдах шинэ нөхцөл хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэнэ. .

Австралийн Мэргэжлийн Зэрэг олгох доод түвшний сургалтын хөтөлбөр лүү шилжих, Австралийн Мэргэжлийн Зэрэг олгох сургалтын хөтөлбөрөөс мэргэжлийн зэргийн ол бус сургалтын хөтөлбөр лүү шилжих суралцах тохиолдолд оюутны визний нөхцлийг зөрчих

бөгөөд улмаар визийг хүчингүй болгох үндэслэл болно. Доод түвшний сургалтын хөтөлбөр лүү шилжихийг хүссэн оюутнууд сургалтын хөтөлбөрөө өөрчлөхөөс өмнө оюутны виз шинээр мэдүүлж, дахин виз авах шаардлагатай..

CRICOS-н бүртгэлтэй итгэмжлэгдсэн сургалтын байгууллагуудын хоорондох шилжих тохиолдолд *Гадаад оюутнуудад сургалт, боловсролын үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын үндэсний практик журмын (2007) 7-р заалтыг мөрдөнө.* . Энэ талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Боловсрол, сургалтын яамны <https://internationaleducation.gov.au/Regulatory-Information/Education-Services-for-Overseas-Students-ESOS-Legislative-Framework/National-Code/Pages/default.aspx> цахим хуудаснаас авна уу.

Сургуулийн салбар шаардлагууд

Сургуульд суралцахад тавигдах насны шалгуур

2016 оны 7-р сарын 1-ний өдрөөс эхлэн сургуулийн сурагчид иргэний харьяаллаас үл хамааран тухайн шатны сургуульд элсэхдээ зохих насны шалгуурыг хангасан байх шаардлагатай. . Оюутны виз авахын тулд тухайн оюутан дараахь насны шалгуурыг хангасан байна. Үүнд:

Хүснэгт 1 – Сургуулийн насанд тавигдах шалгуур

Насанд тавигдах шаардлага
Виз мэдүүлэх үедээ зургаа хүртэлх настай байх;
Ахлах сургуулийн 9-р ангид орох үедээ 17-оос доошгүй настай байх
Ахлах сургуулийн 10-р ангид орох үедээ 18-аас доошгүй настай байх
Ахлах сургуулийн 11-р ангид орох үедээ 19-ээс доошгүй настай байх
Ахлах сургуулийн 12-р ангид орох үедээ 20-оос доошгүй настай байх

Бага сургуулийн сурагчдад олгох визний хүчинтэй хугацаа

Оюутны визийг таван хүртэлх жилийн хугацаатай олгодог боловч бага сургуулийн насны сурагчдад ихэнхдээ хоёр хүртэлх жилийн хугацаатай олгодог. Бага сургуулийн сурагчдад богино хугацаатай виз олгож байгаа нь тэдний насны онцлог болон бусад нөхцөл байдлыг харгалзан үзэж хамгаалах зорилготой юм.

Халамж

18-аас доош насны бүх оюутан, сурагч Австрали Улсад оршин суух хугацаандаа тасралтгүй халамжинд байх ёстой БӨГӨӨД виз мэдүүлэх үедээ дараах маягтуудын аль нэгийг нотлох баримт болгон хавсаргасан байна.

- Австрали Улсад асран халамжлах төрөл төрөгсдийг нэрлэсэн 157N тоот маягт **эсвэл**;
- 157N тоот маягт болон оюутны асран халамжлагчийн 590 ангиллын) визний мэдүүлэг **эсвэл**
- Суралцах гэж буй байгууллагаас зохих орон байр болон халамж үйлчилгээгээр хангах тухай баталгаа бичиг **эсвэл**
- Дунд сургуулийн солилцооны сурагчдын зөвшөөрлийн мэдэгдлийн (ДСССЗМ) маягт гэх мэт

Сургалтын хөтөлбөрүүдийг багцлах

Бодит оюутан хүчинтэй визний хугацаанд хоёр буюу түүнээс олон сургалтын хөтөлбөрийг багцлан нэг хичээлээс нөгөө хичээл руу шилжин суралцах нөхцөл хэвээрээ хадгалагдана. ОХВЖ-ын дагууболовсролын байгууллагууд боловсролын бизнесийн түншүүдээ албан ёсоор томилох шаардлагагүй бөгөөд бусад боловсролын байгууллагатай хамтран сургалтын хөтөлбөрөө багцлах боломжтой байх болно.

Оюутны гэр бүлийн гишүүд

2016 оны 7-р сарын 1-ний өдрөөс эхлэн оюутны визтэй хүмүүсийн гэр бүлийн гишүүд оюутны виз аваагүй бөгөөд цаашид Австрали Улсад байгаагэр бүлийн гишүүдтэйгээ нэгдэх гэж байгаа бол 500 ангиллын виз мэдүүлнэ

Оюутны гэр бүлийн гишүүд тухайн оюутны хойноос Австралид очих болон очих төлөвлөгөөгүй хэдий ч оюутны визний анхны мэдүүлэгт гэр бүлийн гишүүдийг мэдэгдэх ёстой. Визний анхны мэдүүлэгт дурьдагдаагүй гэр бүлийн гишүүд виз авах эрх үүсэхгүй. . Үндсэн виз мэдүүлэгчид (оюутан) виз олгосноос хойш үндсэн виз мэдүүлэгчийн гэр бүлийн гишүүдэд энэхүү шаардлага үйчлэхгүй. энэ 2016 оны 7-р сарын 1-ний өдрөөс эхлэн үндсэн виз мэдүүлэгч (оюутан) нь өөрийн гэр бүлийн гишүүд, асран халамжтай заавал хамт байх шаардлагатай тодорхой сургалтын хөтөлбөрт тавигдах хугацаанд хатуу хязгаар тавихгүй бөгөөд

. үндсэн виз мэдүүлэгчдэд (оюутан) тавьдаг санхүүгийн чадавхийг нотлох шаардлагатай ижил түвшний шаардлагыг гэр бүлийн гишүүд болон асран халамжлагчдадтавина.

Цагаачлалын албаны ажилтнууд шаардлагатай бол хөрөнгийн эх үүсвэрийн нотлох баримтыг шаардах эрхтэй.

Оюутны асран халамжлагчийн виз

Оюутны асран халамжлагчийн виз мэдүүлэгч бүх хүн Австрали Улсад оршин суух хугацаандаа өөрсдийн болон асран халамжлах оюутан/сурагчид, түүнчлэн дагалдах бусад виз мэдүүлэгчдийн амьжиргааны зардлыг даахад хангалттай хөрөнгийн эх үүсвэртэй байх ёстой.

ОХЖ-ын дагуу оюутны асран халамжлагчийн виз мэдүүлэгчдэд цагаачлалын эрсдэлийн нэгдсэн үнэлгээ **үйлчлэхгүй**. Харин бүх асран халамжлагч визийн мэдүүлэгтээ өөрсдийн санхүүгийн чадавхийг н нотлох баримтаа хавсаргах ёстой.

Санхүүгийн чадавхийннотлох баримтыг дараах хэлбэрүүдийн аль нэгээр гаргаж өгч болно:

- Эхнэр/нөхөр нь жилд 70000 австрали доллар буюу түүнээс дээш орлоготойг нотлох баримт; эсвэл
- Эхний 12 сарын турш өөрсдийн болон мэдүүлэгт оруулсан тэжээлгэгч хүүхэд бүрийн аялалын болон амьжиргааны зардлыг даахад хангалттай хөрөнгийн эх үүсвэртэйгээ нотлох баримт.

ОХВЖ-ны дагуу асран халамжлагчдын гэр бүлийн өөр гишүүдийн визний мэдүүлгийг хүлээн авахгүй. Асран халамжлагч зургаагаас доош насны гэр бүлийн өөр гишүүдийг Австрали Улсад авчрахыг хүсвэл шинээр өөртөө болон тухайн оюутныг асран халамжлагчийн виз авсан байна.

Боловсролын салбар тус бүрээр тайланг гаргах

ОХВЖ-ын дагуу Цагаачлалын алба виз олголтын явцыг боловсролын салбар тус бүрээр тайланг гаргана. Боловсролын салбар тус бүрийг хуучин ашиглаж байсан оюутны визний (570– 576) ангилалтай уялдуулан харьцуулалт хийнэ. . Боловсролын салбартай холбоотой мэдээллийг Оюутны виз олгосон тухай бичиг болон Визийгцахим хэлбэрээр (Visa Entitlement Verification Online, VEVO) харуулна.

Оюутны визний мэдүүлгийг хянан шийдвэрлэхэд шаардагдах хугацаа

Цагаачлалын алба бүрэн бүрдүүлсэн оюутны визний мэдүүлгийн 75 хувийг визний мэдүүлэг бүрдүүлж хүргүүлснээс хойш нэг сарын дотор эцэслэн шийдвэрлэх зорилго тавин ажиллаж байна.

Визний мэдүүлгийг хянан шийдвэрлэх хугацааг багасгахын тулд оюутны визний мэдүүлэгт шаардлагатай бүх баримт бичгийг хавсаргасан байна. . Шаардлагатай бүх баримт бичгийг хавсаргаагүй тохиолдолд визний мэдүүлгийг хянан шийдвэрлэх хугацаа алдах болон виз олгохоос татгалзах үндэслэл болно.

Залилан мэхлэх

Цагаачлалын алба зөвхөн үнэн бодит оюутнууд болон тэдний шууд гэр бүлийн гишүүдэд Австралийн оюутны виз олгоход анхаарч ажиллах болно. Залилан мэхлэх явдлыг маш ноцтой авч үзэн, Цагаачлалын албанаас бүрэн шалгалт хийнэ.

Хэрэв виз мэдүүлэгч хуурамч бичиг баримт эсвэл худал буюу төөрөгдүүлсэн мэдээлэл өгсөн буюу өгүүлсэн нь нотлогдвол тухайн виз мэдүүлэгчид виз олгохоос татгалзах буюу визийг нь хүчингүй болгоно. Хэрэв ийм шалтгаанаар виз олгохоос татгалзсан эсвэл визийг нь хүчингүй болгосон бол тухайн виз мэдүүлэгчийн дахин виз мэдүүлэх эрхийг тодорхой хугацаанд түдгэлзүүлж болно.